



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/432

Улаанбаатар хот

Засаг даргын Тамгын газрын Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах зорилгоор Засаг даргын Тамгын газрын Гамшгаас хамгаалах орон тооны бус штабыг байгуулсугай.

2.Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын даргаар Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Нарангэрэлийг томилсугай.

3.Засаг даргын Тамгын газрын Гамшгаас хамгаалах штабын бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэхийг Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын дарга (Б.Нарангэрэл)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Нарангэрэл)-д даалгасугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Дүүргийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/225 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР